

МОНГОЛ ГЭДЭГ НЭРИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙГ ТҮҮХЭН СУРВАЛЖААР МӨШГӨХ НЬ

Б.Ралгаа

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: "Монгол" гэдэг нэрийн гарал, утга учрыг түүхэн үнэнээр гаргаж судлах нь монголчуудын төрт ёсны түүхэн уламжлал, залгамж шинж чанарыг тодруулахад асар их ач холбогдолтой билээ. Монгол угсаатны голлох нэр болсон "Мон" овогтон алс холын зүгээс олон жил нүүдлэн явсаар гурван голын эх бурхан Халдун уулын орчим Онон мөрний эхээр нутаглаж, улмаар энэхүү "мон" овогтноос улбаалан "монгол" гэдэг нэр үүсч аажмаар улс орны ерөнхий нэр болсон болохыг түүхэн сурвалж, судалгааны бүтээлийг ашиглан гаргасан юм.

Түлхүүр үг: Мугула, Мэнгу, Мэну, Мынва, Монг-у, Монгус, Монголжибу, Мунгол, Мугулуй, Монголжин, Монгол гэх мэт.

Монголын түүх гэдэг нь эрхбиш монгол үндэстэн, анх хэдий үед сонсогдож, мэдэгдэж улмаар түүхэнд анх ямар нэрээр тэмдэглэгдэх болсон цагаас эхлэн өгүүлэх аваас сая бодитой, бүрэн бүтэн бодитой түүх хэмээн үзэх учиртай юм. Аливаа улс орны "Түүх хэмээгч нь аль нэг мэргэн өгүүлэгч ба мэргэн зохиогч хүний оюун саналаас зохиогдон гарах бус, чухам түүний (тухайн ард түмний туулж, тэмцэж амьдарч ирсэн түүхэн замнал Б.Р) явсан явдал мөрийг өгүүлэх хэрэг болой"¹ гэж манай төрийн ахмад зүтгэлтэн, түүхч А.Амар аругай хэлсэн билээ.

Иймийн тулд монгол үндэстэн нь анх чухам хэдий үеэс ямар нэрээр эхлэн сонсогдох мэдэгдэх болсон, чухам хаана амьдарч байсан тухайг сурвалж бичиг, түүхэн баримтанд үндэслэн хураангуйлан авч үзэх ёстой юм.

Бидний угсаатан үндэстний ерөнхий нэр болсон "Монгол" гэдэг нэр чухамхүү хэдийд хэрхэн үүссэн, ямар утгатай үг болохыг, одоо болтол эрдэмтэн, судлаачид бүрэн төгс хариу өгч чадаагүй, өөрөөр хэлбэл энэ талаар нэгдмэл ойлголтонд хүрээгүй байгаа юм. Иймээс энэхүү маргаантай асуудалд оновчтой зөв дүгнэлт хийж өгөх нь зайлшгүй чухал ач холбогдолтой.

"Монгол" хэмээх нэр нь нэгэнт угсаатны нэр болоод олон зуун жил болж байгаа учраас түүний гарал үүсэл утга учрыг онол арга зүйн талаар тодорхойлоход бэрхшээлтэй болох нь мэдээж билээ. Гэвч ийм хүнд бэрхшээлтэй асуудал гээд судлаачид бүр хойш суувал цаашид олон зуун жил явсан ч өөрөө аяндаа тодорхой болохгүй нь ойлгомжтой төдийгүй түүхэн баримт, сурвалжууд нь улам бүдгэрэх нь мэдээж юм.

Ийм учраас дотоод гадаадын олон судлаачдын "Монгол" гэдэг нэрийн талаар дэвшүүлсэн таамаглал, дүгнэлтүүдийг түүхэн сурвалж бичиг, бусад баримт материалын үндсэн дээр нилээд нарийн тунгаан нягтлан үзэж өөрийн санал дүгнэлтийг гаргах зорилтыг энэхүү өгүүлэлд тавьсан билээ.

Монгол гэдэг эртний буурал түүхтэй улсын нэрний гарал, утга учрыг тайлбарлах гэж дорно өрнийн олон эрдэмтэн судлаачид бараг 200-аад жил ихээхэн хүч хөдөлмөр, цаг хугацаа, оюун ухаанаа уралдуулан зарж, ном зохиол, бүтээлээ туурвисан боловч одоо болтол нэгдмэл дүгнэлтэнд хараахан хүрч чадаагүй байгаа билээ.

"Монгол" хэмээх нэр хэдийд үүсч гарсан болохыг сурвалж бичиг, судалгааны ном, зохиол, ард түмний дотор гарсан аман домог яриаг үндэслэн үзвэл барагцаалбал "Хоёр мянган жилийн тэртээ нэгэн овог аймгийн нэрийдэл байжээ"² гэсэн дүгнэлтэнд хүрсэн нь МЭӨ 700-аад оноос цааших цаг үеийг

¹ А.Амар. Монголын товч түүх. УБ., 1989. 19 тал

² Рашид-Аддин. Судрын чуулган. I боть, I дэвтэр. УБ. 1994 он. 102 тал

заасан хэрэг ажээ. Гэхдээ "монгол" гэдэг нэр нь нэгэн овог аймгийн оноосон нэр болж байршитлаа нилээд цаг хугацаа өнгөрөөсөн бололттой.

"Монгол" гэдэг нэр нь бичмэл түүх сударт тэмдэглэгдэж эхэлсэн нь хуучин Тан улсын үе буюу VI-VII зууны үеийн нанхиад сурвалжид Му-гула (монгол) мэн-гу³ гэж тэмдэглэснээс үзвэл IV-V зууны үед "Монгол" гэдэг нэр нь үүссэн гэж үзэх үндэслэлтэй болж байгаа юм. Учир нь VI зууны үеийн түүхэн сурвалжид тэмдэглэгдэхийн өмнө "Монгол" хэмээх нэр нь нэгэнт овог аймгийн нэр болон хэвшиж байсан төдийгүй ийнхүү сурвалжид тэмдэглэгдсэн болохоор VI зуунаас өмнө "монгол" гэдэг нь нэгэнт нэршин дадсан байгааг харуулж байгаа юм.

"Монгол татаарын бүрэн тэмдэглэл" хэмээх сурвалжид "Татар улс өмнөд хэмгээр цэю овогтой, баруун ба зүүн талаараа шат болон бусад овогтой хиллэдэг. Эрт үед Монгус (Мэнгусы) улс байжээ" гэсэн байдаг. Уг номын эхэд монгол гэдгийг монгус гэж галиглан бичсэн бөгөөд үгийн адагт нь "С" гэдэг эрт үеийн олон тооны дагавартай бичсэн нь "монгол" гэдгийн "Л" дагавар нь мөн олон тоо илэрхийлдэг бөгөөд орчин цагийн монгол хэлнээ "багачуул, сайчуул" гэдэг олон үгэнд хэрэглэгдэж байна гэсэн сонирхол татахуйц тайлбарыг проф. Ж.Баясах хийжээ⁴.

Тиймээс ч "Хятад болон бусад бичгийн мэдээгээр бол "монгол" гэдэг нь монгол газар нутагт байсан эртний олон аймгийн нэгнийнх нь нэр байсан ажээ. "Хожим салангад аймгууд нийлэн угсаатан болоход нийтийн нь нэр болсон гэдэг санал нилээд магадлалтай юм"⁵ гэж БНМАУ-ын түүхийн нэгэн боть зохиолд онцлон тэмдэглэсэн байдаг.

Ер нь аливаа угсаа удмын уг овог нь аль нэгнийхээ нэрийн дор нэгдэж, ямар нэгэн хугацаанд тодорхой нэг газар нутагт шинэ овог аймаг болж бүрэлдэн тогтох хөгжлийн явцад ихэвчлэн өөрсдөө буюу хөрш орнууд нь тэднийг нэртэй болгодог жамтай. Монголчуудын дээдэс элэнц, хуланц нь мөн л тийм замыг дагаж өөрийн нэртэй болсон нь тодорхой юм. Тэрхүү нэр нь аман болон бичгийн түүхнээ тэмдэглэгдэж хоцрох эсэх нь уул нэрийг зүүгсэд тухайн цаг үедээ нийгэм улс төрийн түүхэн амьдрал, үйл хэрэг явдалд аль хир үүрэг гүйцэтгэж байсантай шууд холбоотой байдаг.

Тиймээс ч "монгол" гэдэг нэр нь олон зуун жил Төв Азийн бичмэл түүхнээ бараг дурсагдахаа байсны учир шалтгаан ч үүнтэй холбоотой төдийгүй, тэр үеийн нахиад сурвалжид Гуй-фан, сянь-юй, гунь-и, жун, ди, ху⁶ гэх мэтээр бидний өвөг дээдэс нүүдэлчин олон аймгуудыг харилцан адилгүй янз бүрээр нэрлэсээр ирсэн байна.

Харин "Монгол" хэмээх нэр нь Хятадын Тан улсын (618-906) үеэс эхлэн Мэн-у, Мын-ва, Мэн-гу, мынг-ва, Монг-у, Монгол гэх зэргээр сурвалжуудад тэмдэглэж ирснээс үзэхэд энэ үед Монгол гэдэг нэрийдэл байсан нь тодорхой байгаа юм. Ийнхүү хятадын түүхэнд тэмдэглэгдсэн олон овог аймгийн дотроос мын-у (монгол) гэдэг угсаатан нь Их шивэй улсын нэгэн аймаг болон Эргүнэ голын дээд урсгал дагуу нутаглаж байсан ажээ⁷ гэж академич Ч.Далай онцлон тэмдэглэсэн байдаг.

"Монгол" хэмээх нэрийн утга учрыг газар нутаг, угсаа гарвал, билэгдэл, шашин шүтлэг, нийгмийн өвөрмөц үзэгдэл болох үүднээс түүхэн сурвалжууд болон эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн таамаглал, дүгнэлт, тайлбарлалтыг ерөнхийд нь хэдэн бүлэг болгон авч хуваан үзэж болох юм Үүнд:

Нэгд. "Монгол" гэдэг үгийг оршин амьдарч байсан газар нутаг, уул ус, гол мөрнийнх нь нэрнээс ургуулан тайлбарлахыг оролдож иржээ. Монголчууд эрт

³ Г.Е.Грумм Гржимайло. Западная Монголия и Урянхайский край Том второй. Ленинград. 1926, 378 тал

⁴ Ж.Баясах. Их монгол улсын түүхэнд холбогдох хяиад хоёр сурвалж бичиг. УБ., 2005. 39 тал

⁵ БНМАУ-ын түүх. Нэгэн боть. УБ.1984. 140 тал

⁶ Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ.1980. 154-155 тал

⁷ Ч.Далай. Монголын түүх. Хамаг монгол улс (1101-1206). Тэргүүн дэвтэр. УБ., 1996 он. 30-р тал

үеэс амьдарч байгаа газар нутгийнхаа уул ус, гол мөрнөөр овог аймаг, улс орныхоо нэр болгодог заншилтай байсан билээ. Тиймээс эрдэмтэн Дорж Банзаров "Хар шүтлэг" гэдэг бүтээлдээ "Онон мөрний хавьд "Мон" хэмээх уул байсан төдийгүй түүний ойролцоо "Мон" хэмээх гол байсан нь "Мон", гол хоёр нийлж "Монгол" болжээ⁸ гэсэн байдаг.

XIX зууны сүүлийн хагаст "монгол" хэмээх нэрийн уг гарлын анхны судалгааг эрдэмтэн Д.Банзаров хийгээд зогсоогүй түүний дэвшүүлсэн таамаглалд нэг зүйл үнэхээр зөв байсан гэж үзүүштэй төдийгүй тэр нь хойч үеийн судлаачид "монгол" нэрийн гарал үүслийг зөвхөн газар зүйн нэрээс хайх хэргийг чиглүүлсэн явдал юм гэж проф. Ж.Баясах тэмдэглэсэн байна.

Үүний далимд тэмдэглэхэд Монголын нутагт Мун хаан уул, Монгол уул, Монгол толгой, Монгол шарын даваа гэх зэрэг нэртэй газрууд олон байдаг төдийгүй, эдгээрийн аль нэгнээс улбаалан монгол гэдэг нэр гарсан ч байж болох талтай.

В.Инжинаш, "дөчин таван сүүдрийн ла сарын шинийн нэгнээ Онон мөрний эх "Мон" нэрт голын амыг эзэлж, мандал цогцлон есөн өглөө тэнгэрээс бэлэг гуйж хаан суусан бүлгээ"⁹ гэж Чингисийг хаан ширээнд суусныг тэмдэглэжээ. Энэхүү түүхэн сурвалжаас үзвэл ямар ч гэсэн "Мон" гэдэг уул болон гол нь Онон мөрний эх орчим байсан тухай бусад сурвалж болон холбогдох түүхэн баримтуудаар батлагдаж байгаа юм.

Өвөр монголын эрдэмтэн Сүрбадрах "мон" гэгч нь уул буюу голын нэр байж, тэр хавьд оршин амьдрагчдыг "Мон" гэдэг төдийгүй "Мон-Гол"-ын "гол" гэдэг нь голлох (цөм, мөхлөг, төв) гэсэн утгатай¹⁰ гэжээ.

Оросын эрдэмтэн Г.Е.Грумм Гржимайло, судлаач Намжилцэвээн нар нь дээрх саналуудтай ойролцоо санал гаргаж "Мон" гэдэг голын орчим "Мон" хэмээх овог аймгууд амьдарч байснаас "монгол" гэдэг нэр үүсчээ¹¹ гэдэгтэй санал нэгдэж байгаа юм.

Хоёрт: "Монгол" гэдэг нь овог аймаг, угсаатны нэрнээс үндэслэнэ гэж үзэж байгаа юм.

В.Инжинаш, "Чингисийг хаан суух үед 36 их улсыг тоочиход "Мон", "Монголжибу" ... гэсэн аймаг ороод зогсоогүй энэхүү ..."Монголжибу аймгийг эзэлсэн Мон улсын голд чуулж¹² гэсэн баримтаас үзэхэд "мон" хэмээх нэр нь нилээд эрт үүссэн болохыг нотолж байгаа юм. Рашид-Аддины Судрын чуулганд "Одоо үе хүртэл барагцаалбал хоёр мянган орчим жилийн тэртээ эрт цагт монгол гэж аймаг"¹³ оршиж байсан тухай аман домгийн уламжлалыг дурдаад тэрхүү "Монгол" хэмээгдэх аймаг нь эргүнэ гунгээс нүүдлэн гарч ирэхдээ урт замыг туулан явсаар Онон мөрний эхэнд ирж нэгэн жижиг салаа голын орчимд нутагласныг өгүүлсэн байдаг. Түүнчлэн Судрын чуулганд "Монгол" гэдэг үг тэдгээрийн овгийн нэр", "Монгол" гэдэг нь анхлан "Мун-гол" гэгдэж байсан гэж тэмдэглэжээ¹⁴.

Хятадын эрдэмтэн Ван-Го-Вей, Хун-Цзю нар "Монгол нэрийн судалгаа" гэсэн бүтээлдээ "Монгол" гэдэг нь түүхэнд байсан нэгэн ястан аймаг байж тэр нь үе улирсаар нийт монголчуудын нэр болсон гэсэн утгаар тайлбарлажээ¹⁵.

Японы судлаачид хятадын эртний түүх судар болон манай зарим үгийн утга санааг дүрс бичигт зохицуулан тайлбарлалт хийх оролдлого хийсэн байдаг. Тиймээс ч японы судлаач Яно-Жин-ичи "Ойрх үеийн монголын шинэ үеийн

⁸ Дорж Банзаров. Собрание сочинения. М.1955 гг. стр.167-168

⁹ В.Инжинаш. Их Юань улсын мандсан төрийн Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот. 1991 он. 49 тал

¹⁰ Дэлхий дахины түүх. I боть. Ред.Ж.Болдбаатар, З.Баасанжав. УБ., 2002 он. 115 тал

¹¹ Намжилцэвээн. Монгол гэдэг нэрийн тухай. УБ., 1959 он. 11-12 тал

¹² В.Инжинаш. Их Юань улсын мандсан төрийн Хөх судар. Дэд дэвтэр. Хөх хот. 1991 он. 1152-1153 тал

¹³ Рашид Аддин. Судрын чуулган. I боть. I дэвтэр. УБ., 1994 он. 102 тал

¹⁴ Рашид Аддин дээрх зохиол. I боть. I дэвтэр. УБ. 1994 он. 103 тал

¹⁵ Ч.Далай. Монголын түүх. Хамаг монгол улс. Тэргүүн дэвтэр. УБ., 1996 он. 31-32 тал

түүхийн судалгаа” гэсэн бүтээлдээ “Мын-вэ” нэртэй аймаг шилик голын орчим нутаглаж байсан бөгөөд тэр нь монгол аймаг төдийгүй тийм нэртэй ястан овгууд байсан байна. Мөн Коба-яси, “Монголын нууц товчоо” гэдэг зохиолдоо монгол гэдэг нь монгол овгуудын дотор байсан “Мангуд” гэсэн нэгэн овог явсаар монгол болжээ гэсэн бол “Мон” гэдэг овгоос улбаатай жинхэнэ “Монгол” хэмээх нэр үүсчээ гэсэн байдаг¹⁶.

Оросын эрдэмтэн Г.Е.Грумм Гржимайло “Монгол” гэдэг нь тусгай үндэстний нэр ... дээр үед үүссэн боловч Чингисийн үед Монгол гэдэг нэр алдаршив¹⁷ гэсэн бол Л.Л.Викторова “Монгол” гэдэг нь угсаатны нэрнээс гарсан гэх зэргээр тайлбарласан байгаа юм¹⁸. “Монгол” гэдэг нэрийн учир холбогдлыг дээрх судлаачид олон сурвалжийн мэдээг бусдаас илүү онож ухааран ашиглаж бас түүнийгээ Судрын чуулган, Нууц товчоо зэрэг түүхэн чухал сурвалжуудтай харьцуулан нилээд ул үндэстэй судалсан байгааг харуулж байгаа юм. Монголын эрдэмтэн Д.Гонгор “Халх товчоон” гэсэн бүтээлдээ Эргүнэ-кунаас гарсан монгол овогтны тухай тодорхой дурдаад “Монгол” гэдэг нь угсаатны нэр¹⁹ гэдгээр тодорхой тайлбарласан бол эрдэмтэн Г.Сүхбаатар, “Монгол” гэгддэг овог нь монгол Нирун улс ба түүний өмнөх үед үүссэн гэжээ²⁰.

Эдгээр түүхийн тулгар баримт бичиг, сурвалжууд болон судалгааны бүтээлүүд нь хоорондоо нягт холбоотой бичигдсэн учраас өгүүлсэн гол утга санаа нь монгол нэрийн гарал үүслийн хувьд ойролцоо буюу адил нэг бүхэл санааг тодорхой гаргасан байгаа юм.

Гуравт: Монгол хэмээх нэрийг шашин шүтлэг, бөө мөргөл, билэгшээх ёсны үүднээс ургуулан тайлбарлаж ирсэн байгаа юм. Өвөр монголын эрдэмтэн Элэндэй, Э.Ардаажав нар “монгол” гэдэг үгийн гарлыг тайлбарлахдаа “Монголчууд бөөгийн мөргөлтэй байсан болохоор Мөнки-тэнгр-гал” гэдэг үгийн “ка-тэнгри” нь гээгдээд “мөнг-гал” болж, улмаар хоёрдугаар үеийн эгшиг нэгдүгээр үеийн эгшигтэй ижилсэн “монгол” болов. Энэ нь “мөнхрөх” гэсэн утгатай гэжээ²¹. Эрдэмтэн Дорнотив, “Монгол гэдэг бол мөнх тэнгэр гэснээс хувирч ирсэн юм²² гэсэн байна гэж дээрх судлаачдын үзэл бодлыг дэмжсэн байдаг. Японы эрдэмтэн Ширатори, Коба яси, Мураками нар “монгол” гэдэг нэрийн гарал үүсэл, утга санааг “Өнө мөнх орших, харин “Мангуд” гэсэн овгийг “Мөнх” гэдэг үгтэй холбоотой гэх мэтээр тайлбарлажээ²³.

Ийнхүү “Монгол” хэмээх нэрийг монголчуудын дотоод амьдрал, мөнх тэнгэр, бөө мөргөл, зан заншил, аман домогтой холбон билэгдлийн шинжтэйгээр дээрх судлаачид тайлбарлажээ.

Дөрөвт: Монгол хэмээх үгийн гарлыг биш, харин утга санааг янз бүрээр тайлбарласан байдаг.

“Хар татарын хэргийн товч”-д “Монгол” хэмээх нэрийн уг гарлыг тайлахад түлхүүр болмоор маш чухал баримтууд байдаг. Тухайлбал “Хар татар улс (хойт шаньюй буюу) Их монгол хэмээсэн цолтой билээ. Говийн элснээ монгол гэдэг уул бий. Татаар хэлэнд мөнгө гэсэн утгатай бөгөөд зөрчид, өөрийн улсаа Их Алтан улс хэмээн нэрийдсэн учир, татарууд улсаа мөнгө хэмээн нэрийдэв” гэжээ.

¹⁶ Ч.Хасдорж. Монгол гэдэг нэрийн тухай. УБ.,1960 он. 12 тал

¹⁷ Г.Е.Грумм Гржимайло. Западная монголия и урянхайский край. Том II. Л-1976.стр 370

¹⁸ Л.Л.Викторова. Монголы-происхождение народа и истоки культуры. М.1980 г. стр 105

¹⁹ Д.Гонгор. Халх товчоон. I дэвтэр. УБ. 1970 он. 44 тал

²⁰ Г.Сүхбаатар. Монгол нирун улс. УБ., 1992 он. 180 тал

²¹ Элэндэй. Ардаажав. Монголын нууц товчооны сийрүүлэл тайлбар. Хөх хот. 1986 он. 80-81 тал

²² Ч.Далай. Өмнө дурьдсан зохиол. 34 тал

²³ Ч.Далай. Өмнө дурьдсан зохиол. 32 тал

Түүхч, зохиолч В.Инжинаш "Монгол хэмээх нэрийг хятадаар "Мэн-гу" гэж бичмүй. Энэхүү "Мэн-гу" хэмээх хоёр үгсийн утгыг тайлбал "Эртний төлөвт" хэмээх үг болмуй" гэж²⁴ тайлбарлажээ.

Оросын эрдэмтэн П.Шмидт монгол гэдэг үгийн утгыг "зоригтой", "зүрхтэй" үг гэж тайлбарласан нь манай "мундаг зоригтой" гэсэн үгийн язгуур нь гэж үзсэн нь нилээд сонирхолтой саналыг дэвшүүлсэн байдаг. Мөн зохиолч В.Ян монгол гэдэг нь "ялан дийлсэн" гэсэн утгатай гэжээ. М.С.Боднарскийн зохиосон "Словарь географических названий" гэдэг толь бичигт монгол гэдгийг "ялагдашгүй эрэлхэг" гэсэн утгатайгаар тайлбарласан байдаг бол, Г.М.Рамстедт, мөнх тэнгэрийг газар устайгаар холбон монгол нэрийг тайлбарласан нь нилээд сонирхолтой байдаг.

Түүхч Ломи, "Монгол гэдэг нь "Мон" хэмээгч нь олныг мөхөөж дайлаад дутаав гэсэн үг... "Монгол гэдэг нь Мон+гол гэсэн хоёр үгнээс бүрдсэн дэлхийг ноёрхсон хүчирхэг дэлхийн төв гол улс байсан гэж тайлбарлажээ²⁵.

Японы эрдэмтэн Куба-яси, Фукуба нар "монгол" хэмээх нэрийн талаар японд гарсан саналуудыг нилээд нухацтай үзээд, түүний утгыг монгол үгнээс эрэхдээ түүнтэй ойролцоо авиа, дуудлагатай "мөнх", "мөнгө" гэсэн үгнээс гарсан байж болох талтай төдийгүй, монгол гэсэн үгийн монго бол "Мөнх" үг²⁶ гэжээ. Д.Оссоны "Монголын түүх хэмээх зохиолд "Мэнгу" монгол гэгч нь түрэг хэлэнд "мөнх тэнгэрийг заана... 4 мэнгу" гэдэг нь түрэг хэлэнд мөнхрөхийг хэлнэ²⁷ гэж бичжээ.

Нөгөө талаар эрдэмтдийн судалгаанаас үзвэл "мон" гэдэг үг нь эрт дээр үед "элбэг дэлбэг", "ихээхэн", "дуусашгүй" гэсэн утгаар ярианы хэлэнд хэрэглэгдэж байсан бололтой. Эцэст нь тэмдэглэхэд "монгол" гэдэг нэр нь хөх тэнгэртэй холбоотой бөгөөд хөх тэнгэрийн орон гэсэн утга санаа ямар нэг хэмжээгээр шингэсэн байх талтай юм.

Тавд: Монголын нилээд "Монгол" хэмээх нэрийн гарал үүслийг шинжлэх ухааны системын хандлагын үүднээс ул суурьтай авч үзэн нийгмийн үзэгдэл болох талаас нь нилээд үндэслэлтэй тайлбарласан байдаг.

"Монголын нууц товчоо", Раашпунцагийн Дай Юань улсын болор эрих, Галдангийн "Эрднийн эрх" болон зарим монгол хэлний толь бичигт "эрийн мун" гэж байдаг нь эр хүний зовж зүдрэхийг хэлсэн санаа төдийгүй "мун" гэдэг үгнээс манай мунгинах, мунгинасан үгсийн язгуур гарсан гэж үздэг. Түүнчлэн зарим сурвалжуудад "мундах буюу мөнөө үзүүлтэл мунгинасан, чармайсны үр дүнд гол төлөв улс болсноос монгол гэж нэрлэв"²⁸ онцлон тэмдэглэсэн нь олон овог аймгууд, хүнд бэрхшээлийг даван туулж цөм нь болсноос "монгол" хэмээх нэр үүссэн гэсэн судлаачдын дэвшүүлсэн таамаглал нь нилээд үндэслэлтэй болж байгаа юм.

Монголын нэрт эрдэмтэн Х.Пэрлээ Монгол гэдэг нэр нь "мунгинасан, монгиносон" гэсэн утгатайгаар нийгэм олны амьдралын үзэгдлээс үүдэн гарсан²⁸ хэмээн тайлбарласан нь нилээд оновчтой болсон байдаг. Энэ нь Монголчуудын өвөг дээдэс, Эргүнэ-кунэ гэдэг нутгаас гарч, асар их бэрхшээлийг даван мунгинан будилж, холын замыг туулж явсаар гурван голын эхээр ирж нутагласныг хэлж байгаа юм.

Монгол гэдэг нэр нь монгол угсаатны дотроос гарсан монгол үг учир түүний гарал үүсэл, утга санааг монголчууд арай илүү бодож олох учиртай. Иймээс монгол сурвалжид "Мон" улс болов гэж монгол улс хэмээн олонхийг

²⁴ В.Инжинаш. Их Юан улсын мандсан төрийн Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот. 1991 он. 35 тал

²⁵ Ломи. Боржигин овгийн түүх. Хөх хот. 1989 он. 55 тал

²⁶ Ч.Далай. Өмнө дурьдсан зохиол. 31 тал

²⁷ Галдан. Эрднийн эрих. Хөх хот. 1999 он 75 тал

²⁸ Х.Пэрлээ. Гурван мөрний монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь. УБ., 1969 он 91-92 тал

нэрийдсэнээр монголын боржигин овогтон хиад ястан болов"²⁹ гэж Дармаа гүүш тэмдэглэжээ.

Эрдэмтэн Г.Сүхбаатар, хятадын "Вэй-шү" хэмээх (386-535) төрийн түүхэнд (Вэй улсын судар) "Тобагийн морьт цэрэг "Мэгэ" гэдэг аймгаас нэгэн хүү олзлон ирээд уг аймгийн нэгэн нэрээр "Мугулюй" нэр өгснөөс улбаалан монгол нэрийн талаар сонирхолтой гаргалгаа хийсэн байдаг. Тэр хүү "мугуюй" нь хожим Нирун улсын үндэс суурь болж, эл нэрийн дуудлага нь "монгол" хэмээх нэрийн хятад сурвалжийн олон янзын дуудлагатай дүйцэж байгаа юм. Бас хятад сурвалжид тэмдэглэгдэж ирсэн "мугулюй" гэдэг үгийн утга нь Перс сурвалжийн "монгол" гэсэн утгатай тохирч байгаа юм.

"Мугулюй" нь угсаатны ерөнхий нэр, өөрөөр хэлбэл нирунчуудын нийтийн өвөг, овгийн нэр болохоор нирунчуудын удмынхан Нирун улс мөхснөөс хойш ч гэсэн "мугулюй" овогтон байсан юм. Нөгөө талаар Мугулюй (мугул) монгол хоёрыг нэгэн угсаатны ерөнхий нэр гэж хэл шинжлэл, түүх, соёл угсаатны ерөнхий зүйн баримтаар бүрэн нотлогдож байгаа гэсэн дүгнэлтийг нэрт эрдэмтэн Г.Сүхбаатар хийсэн билээ³⁰.

В.Инжинаш "Богд эзэн гучин хоёр жил хаа хүрвч тэр улсад хүндлэгдэн эрхэмлэгдэж, эзэн бүр ирж манай Бэта улсын зуун түмнээ эртний "Монголжиху" аймгийг эзэлсэн Мон нэрт улсын голд чуулган чуулж, өсөн өрлөг тэнгэрийн хаан ширээнд суусан тул манай энэ улсыг хүндлэхүйн дээд "Хөх монгол улс" хэмээсүгэй"³¹ гэж тэмдэглэжээ.

Академич Ч.Далай "X-XI зууны үед "монгол" буюу "мон" голынхон гэдэг "төв овог" буюу монгол хэмээх "гол аймаг" гурван голын эхээр нутаглаж байсан нь" түүхийн сурвалж мэдээ, баримт, аман домог түүх болон эрдэмтдийн судалгаагаар нэгэнт нотлогдож байна"³² гэсэн дүгнэлтийг анх удаа хийж байгаа нь маш оновчтой болсон байна.

Ер нь ихэнх судлаачид "монгол" хэмээхийг "мон" овогтноос улбаалан голлон (цөм) угсаатан голлогч аймаг болсон нь юм гэж тайлбарласан байдаг. Ингэхээр "монгол" гэдэг нэр нь нэн эртнээс монгол нутагт оршин амьдарч он цагийн элэлийг даан батжин төлөвшсөн нэр, нийгэм, түүхийн үзэгдлийн олон талт цогц илэрхийлэл болсон байна.

Түүхийн сурвалжууд болон өрнө, дорнын олон эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн таамаглал, дүгнэлтүүд, бусад мэдээ сэлтийг үндэслэн тэдгээрийг ургуулан бодож үзнээс "Монгол" гэдэг нэр нь Эргүнэ-куны домогт тусгагдсан "мон" овогтон бөгөөд тэр нь III-IV зууны үеэс эхлэн нанхиад сурвалжуудад "мэнгэ", "Мэн-гу-ли", "мын-ва", "мугулюй" гэх мэтчилэн тэмдэглэгдэж ирсэн нэгэн ястан, угсаатан нэрнээс уламжлагдан гарсан гэж үзэх үндэслэлтэй байгаа юм. Энэ нь бидний өмнө өгүүлсэн түүхэн зарим сурвалжууд, бусад баримт материал, судлаачдын хийсэн дүгнэлтүүдээр нотлогдож байгаа юм.

Өөрөөр хэлбэл, олон зуун жилийн тэртээгээс түүхчлэн бичсээр ирсэн монгол угсаатны голлох нэр болсон тэрхүү "Мон" овогтон алс холын зүгээс олон жил нүүдэллэн зовж, тэмцэн явсаар гурван голын эх бурхан Халдун уулын орчим, онон мөрний эхээр нутаглажээ. Тэр үед Онон мөрний дээд урсгалын дагуу амьдран суурьшсан "Мон" овогтныг "Мон" голынхон буюу "Монгол" гэж нэрлэсэн гэж үзэх үндэслэлтэй.

Иймд "Мон" овгийнхон "гол улс" болон явсаар сүүлдээ түүнээс улбаалан "Хамаг монгол" гэж нэрлэгдэн аажмаар улс орны ерөнхий нэр болсон юм гэсэн дүгнэлтийг хийж болох юм.

²⁹ Дармаа гүүш, Алтан хүрдэн мянган хигээст. Хөх хот. 1987 он. 17 тал

³⁰ Г.Сүхбаатар. Монгол Нирун улс. 330-555 он. УБ., 1992. 176-180 тал

³¹ В.Инжинаш. Их юань улсын мандсан төрийн Хөх судар Хөх хот. 1991., Дэд дэвтэр. 1167-1168 тал

³² Ч.Далай. Монголын түүх. Хамаг монгол улс. (1101-1206). Тэргүүн дэвтэр. 35 тал

Ийнхүү сурвалж бичгүүд, түүхэн баримт, судалгааны бүтээлүүдэд хийсэн дүгнэлтээс үзвэл "мон" хэмээх нэр нь овог аймаг, угсаатны нэр байснаа аажмаар "монгол" гэж өөрчлөгдөн улс гэрийн ерөнхий нэр болсон байна. Тухайлбал:

Нэгдүгээрт: VII-VIII зууны үед Эргунэ-кун орчим амьдарч байсан монголчуудын овог дээдсийг "Дарлигин" хэмээх ерөнхий нэрийн дор түүхэнд тэмдэглэгдсэн төдийгүй, янз бүрийн нэртэй олон овгууд байсны дотор "мон" овогтон байсан нь түүхэн сурвалжаар нотлогдож байгаа юм. **Хоёрдугаарт:** IX-X зууны үед "монгол" хэмээх нь мэнгү шивэй, монголжиху, монглу, монголжин гэх мэтээр овог аймгийн нэр болоод богсоогүй, гурван голын эхээр нутаглаж байсан овог аймаг нь "Мон" голынхон гэдэг төв овог буюу "монгол" гэдэг нэртэй болж байсан юм. **Гуравдугаарт:** XI-XII зууны үед "Монгол" хэмээх нэр нь аймгийн холбооны нэр болоод зогсоогүй, Хабул Хотул, Амбагай хааны үед "Хамаг монгол" гэж жинхэнэ ханлиг (улсын) нэр болжээ. **Дөрөвдүгээрт:** XIII зууны эхний хагаст Хамаг монголын нэр нь Их монгол нэрээр солигдож, хааны цол нь Далай хаан эзэн болжээ. **Тавдугаарт:** Юаны Монгол гүрэн болон хүчирхэгжиж, бие даан оршин тогтносоор хятадын Мин улсын үед, Ар Юаны Монгол буюу бага хаадын монгол, Дөчин дөрвөн хоёрын монгол гэх мэт нэртэйгээр баахан тархай бутархай шинжтэй оршиж оршиж байсан юм. **Зургаадугаарт:** XVI зууны үеэс "Ар монгол, Өвөр монгол, Ойрод монгол Халхын хаант улс гэх мэт нэртэйгээр оршиж байгаад улмаар Манжид эзлэгдэн тусгаар тогтнолоо алдсан юм. Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд 1911 онд Олноо өргөгдсөн Монгол улс байгуулагдаж улмаар 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгал ялж, 1924 онд БНМАУ гэсэн нэртэйгээр улс орноо дэлхий дахинд тунхагласан билээ. 1992 онд БНМАУ гэсэн нэрээ өөрчилж, уламжлалт нэрээ сэргээн Монгол улс гэж нэрлэх болсон билээ.

Чухамхүү манай ард түмэн "Монгол" хэмээх нэрээр овоггноороо бахархаж, Монгол улсынхаа тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэж, эх орныхоо бүрэн эрхт эзэд нь болсон билээ.

Монголчууд бид даруухан түүх шасдиртай улс мөртлөө монгол гэдэг нэрийн дор хүчирхэгжин мандахын буяныг эдэлж зарим үед буурын доройтох гунигийг амсаж явсан билээ. Өөрөөр хэлбэл Монгол гэдэг нэртэй улс өрөөл бусдыг эзэгнэж, жөтөөч хүчинд басамжлагдаж явсан тийм нэг үндэстэн Төв Азийн өр зүрхэнд XX зууны эхэн үед дахин сэргэн гарч ирснийг, өнөөдөр дэлхийн 143 улс гүрнүүд хүлээн зөвшөөрч найрсгаар хандан туслан дэмжиж, хамтран ажиллаж байна.

Abstract: After many years of migration "Mon" family tribes, who were the main representatives of the Mongol nationality, have reached the area nearby Burkhan Halduun Mountain on the bank of the Onon River. Thereafter, the name "Mongol" appeared deriving from "Mon" family name, which gradually became the main term for naming the whole state.

Ном зүй

1. Монголын нууц товчоо. УБ., 1990 он
2. БНМАУ-ын түүх. УБ., 1984 он. Нэгэн боть
3. Монгол улсын түүх. УБ., 1999 он
4. В.Инжинаш. Их Юань улсын мандсан төрийн Хөх судар. Хөх хот. 1991 он
5. Ломи. Боржигин овгийн түүх. Хөх хот. 1989 он
6. Раашпунцаг. Дай Юань улсын болор эрих. Хөх хот. 2000 он
7. Галдан. Эрдэнийн эрих. Хөх хот. 1999 он

8. Дармаа гүүш. Алтан хүрдэн мянган хигээст бичиг. Хөх хот. 1987 он
9. Рашид-Аддин. Судрын чуулган. УБ., 1994 он. I боть, I боть. I дэвтэр
10. Г.Е.Грумм Гржимайло. Западная монголия и Урянхайский край, том II. Ленинград, 1926
11. Х.Пэрлээ. Гурван мөрний монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь. УБ., 1969
12. А.Амар. Монголын товч түүх. УБ., 1989
13. Дорж Банзаров. Собрание сочинения. М.1955 гг
14. Л.Л.Викторова. Монголы-происхождение народа и истоки культуры. М.198
15. Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980
16. Г.Сүхбаатар. Монгол нирун улс. (330-555). УБ., 1992
17. Д.Гонгор. Халх товчоон. I дэвтэр. УБ., 1970
18. Ч.Далай, Монголын түүх. Хамаг монгол улс (1101-1206). тэргүүн дэвтэр. УБ., 1996
19. Дэлхий дахины түүх I боть, Ж.Болдбаатар, З.Баасанжав. УБ., 2002 он
20. Сайшаал. Чингис хааны товчоон. дэд дэвтэр УБ., 2004
21. Элдэнтэй, Э.Ардаажав. Монголын нууц товчооны сийрүүлэл. Тайлбар. Хөх хот. 1986
22. Намжилцэвээн. Монгол гэдэг нэрийн тухай. УБ., 1959
23. Ч.Хасдорж. Монгол гэдэг нэрийн тухай. УБ., 1960
24. Түүх-III, МУИС.ЭШБ. № 228 (23). 2004
25. Христианский мир и великая монгольская империя. Материалы францисканской миссии. 1245 г. Санкт-Петербург. 2002 г
26. Ж.Баясах. Их монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. УБ., 2005